ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон П Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253
Цахим шуудан uvurkhangai@audit gov mn
Цахим хуудас www.audit mn

2026.04.17 № 316

танай ____________-ны №____________-т

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
МОНГОЛ АРДЫН НАМЫН
ХОРООНД

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5 дахь хэсгийг үндэслэн Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох аймгийн Монгол ардын намын хорооны Сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүргүүлж байна.

Хавсралт 30 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР О БАТЖАРГАЛ

6225020508

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНД

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас www.audit.mn

2026-04-17 № 197

танай ____________-ны №____________-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 5.4-т заасны дагуу Төрийн аудитын байгууллага Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох Өвөрхангай аймгийн Монгол ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох Өвөрхангай аймгийн Монгол ардын намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох Өвөрхангай аймгийн Монгол ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн

иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Өвөрхангай аймгийн Монгол ардын намын хорооны Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Өвөрхангай аймгийн Монгол ардын намын хорооны мөрийн хөтөлбөр (37 хуудас)-ийг хавсаргав

Хувийг: Өвөрхангай аймгийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН 2024 ОНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

| | |
|---|---|
| | **1. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ – АЖИЛ ОРЛОГОТОЙ ИРГЭН** |
| 1. | Арвайхээр – Баянгол – Сайхан-Овоо – Мандал-Овоо чиглэлийн 230 км авто замын ТЭЗҮ-ийг батлуулан, ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. |
| 2. | “Орхон-Онги” эко төслийг үе шаттайгаар хэрэгжүүлж аймгийн төсвийг бие даан бүрдүүлэх үндэс суурийг тавина. |
| 3. | Арвайхээр – Шивээхүрэн боомт чиглэлийн 336 км авто замын ТЭЗҮ-ийг боловсруулан батлуулж, барьж дуусгана. |
| 4. | Арвайхээр-Хужирт чиглэлийн 43.3 км хатуу хучилттай автозамыг ашиглалтад оруулна. |
| 5. | Арвайхээр – Сант – Мандалговь – Чойр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн автозамаас Өвөрхангайн нутагт хамаарах Арвайхээр – Сант чиглэлийн 150 км автозамыг барина. |
| 6. | “Шинэ Хархорум хот”-ын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, төмөр зам, автозамын ТЭЗҮ-г батлуулан, хэрэгжүүлж эхлүүлнэ. |
| 7. | Арвайхээр – Шивээ хүрэн боомт чиглэлийн авто зам тавихтай холбогдуулан барилгын материалын бөөний төв, тээвэр логистикийн төвийг байгуулна. |
| 8. | Төр, хувийн хэвшлийн түншлэлээр ардас баялгийн илэрцийг эдийн засгийн эргэлтэд оруулж, дэд бүтэц, үйлдвэр байгуулах бодлого хэрэгжүүлж, "Өвөрхангайн хөгжил" орон нутгийн санг хууль тогтоомжийн хүрээнд байгуулна. |
| 9. | Үйлвэрлэл хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж, дотоодын нийт бүтээгдэхүүнийг 2 дахин нэмэгдүүлнэ. |
| 10. | Төр нь хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчим баримталж, зарим орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүдийг бизнесийн зарчмаар хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ. |
| 11. | Баянтээгийн нүүрсний уурхайн техник технологийг шинэчлэн, ашигт ажиллагааг нэмэгдүүлнэ. |
| 12. | Иргэд олон нийтийн санхүүгийн зах зээлийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцох, хуримтлал, хадгаламжтай болох хандлагыг нэмэгдүүлнэ. |
| 13. | Дотоодын захзээлд аймгийн бонд гаргах замаар ажлын байр бий болгох, нийгэм, эдийн засгийн хөгжлийг түргэтгэх томоохон төсөл, хөтөлбөрүүдэд хөренгө оруулалт хийнэ. |
| | **2.ХОТ БАЙГУУЛАЛТ – АМЬДРАХ ТААТАЙ ОРЧИН** |
| 1. | Инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй 9 суманд инженерийн шугам сүлжээ, цэвэршүүлэх байгууламж барьж, Хархорин сумын инженерийн шугам сүлжээг шинэчлэнэ. |
| 2. | Бүх сумдыг иженерийн шугам сүлжээтэй болгон, түүнийг дагуулж, орон сууцны хороолол, “Пассив хаус” хорооллын төсөл хэрэгжүүлнэ. |
| 3. | Боржин чулуу, цемент, хайрга, бетон үйлдвэрлэлийг хөгжүүлж, барилгын дүүргэгч материалын хэнгамжийн төв байгуулна. |
| 4. | Арвайхээр хотыг, хангайн бүсийн бараа, барилгын материал, мэдээлэл, технологийн тулгуур төв, ухаалаг эко хот болгон хөгжүүлнэ. |
| 5. | Хүнд даацын автомашины тээврийн зогсоолыг Арвайхээр хотын гадна байршуулж, хотын доторх авто замын эвдрэлээс сэргийлнэ. |

| | |
|---|---|
| 6. | Арвайхээр, Хужирт, Уянга, Нарийнтээл, Бат-Өлзий сумдад үерээс хамгаалах далан сувгийн байгууламжийн угсралтын ажлыг хийж гүйцэтгэнэ. |
| 7. | Арвайхээр сумын 12 айлын 3 орон сууц, 36 айлын 2 орон сууц, хангамжийн болон эрчмийн 24 айлын орон сууц, 48 айлын 2 орон сууц, зарим гэр хорооллыг орон сууцны дахин төлөвлөлт оруулна. |
| 8. | Арвайхээр хотын дулааны станцыг ашиглалтад оруулж, нийтийн орон сууцнуудыг хэрэглээний халуун усаар хангаж, хуучин орон сууцнуудын дээвэр, гадна фасад, орц, орчны тохижилтыг хийнэ. |
| 9. | Бүх сумдын төвд авто болон явган зам, талбайн засвар шинэчлэл хийнэ. |
| 10. | Хархорин суманд усан бассейн барьж, ашиглалтад оруулна. |
| 11. | Арвайхээр суманд төр хувийн хэвшлийн түншлэлээр усан парк байгуулна. |
| 12. | Бүсийн төв болох Гучин-Ус, Сант, Есөнзүйл, Хархорин, Арвайхээр сумдад үйлдвэрлэлийн бүс байгуулж, дэд бүтцийг шийдвэрлэнэ. |
| 13. | Гудамж талбай, нийтийн эзэмшлийн талбайн гэрэлтүүлгийг сэргээгдэх эрчим хүчээр шийдвэрлэнэ. |
| 14. | Бүх сумдад "Тохижилт үйлчилгээний компани"-ийг төрийн болон хувийн хэвшлийн оролцоотойгоор ажиллуулж орчин үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр хангана. |
| 15. | Арвайхээр хотод IoT" камер, хэмжилтийн мэдрэгч төхөөрөмжүүдийг иж бүрэн суурилуулна. |
| 16. | Хүн амын төвлөрөл ихтэй сумдад цэцэрлэг, сургуулийг гэр хорооллын дунд байгуулж "Хамгийн сайн сургууль гэрт ойрхон сургууль" зарчмыг хэрэгжүүлнэ. |
| 17. | Бүх сумдын төвүүдэд 100 км дугуйн болон явган замыг шинээр барина. |
| 18. | Арвайхээр хотын дундуур урсах Дэлгэрэх голын эх орчимд усан сан, хөв, цөөрөм байгуулж хот дотор гол, горхины толио үүсгэн, урсацад тохируулга хийнэ. |
| 19. | Төсвийн дэмжлэг үзүүлж "Сууц өмчлөгчдийн холбоо"-ны үйл ажиллагааны төрөл хэлбэрийг шинэчилэн, үйлчилгээний чанарыг сайжруулна. |
| 20. | Бүх сумдын төвүүдийн эрчим хүчний хүчдэлийн уналтыг бүрэн шийдвэрлэж, цахилгааны модон шонгуудыг бетон тулгуураар сольж, цахилгаан түгээх утсыг СИП кабелаар сольж, цахилгааны ухаалаг тоолууруудыг суурилуулна. |
| 21. | Бүх сумдад түрээсийн орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлж, орон сууцыг түрээслээд өмчлөх хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлүүлнэ. |
| 22. | Арвайхээр суманд суурьшлын 3 дахь шинэ төвийн төлөвлөлтийг хийж, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ. |
| 23. | Газар төлөвлөлтийн үеийн процессыг олон нийтэд нээлттэй болгож, газар олголтыг иргэд, аж ахуйн нэгжүүдэд хүрэлцээхүйц хэмжээнд хүргэнэ. |
| 24. | Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын систем бий болгож, газрыг нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлнэ. |
| 25. | Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон сумдын газар зохион байгуулалт, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулна. |
| **2.1 ДЭД БҮТЭЦ – ХӨГЖЛИЙН ГАРЦ** | |

| | |
|---|---|
| **2.1.1. Харилцаа холбоо, эрчим хүч** | |
| 1. | Аймгийн бүх нутаг дэвсгэрийг үүрэн холбооны сүлжээнд холбоно. |
| 2. | Нарийнтээл сумын Баянтээг багийг шилэн кабельд холбоно. |
| 3. | "Баянтээг" ХК-ийг түшиглэн 100 мВт хүчин чадалтай цахилгаан станц барина. |
| 4. | Уянга сумын Онгийн голд 3.0 мВт хүчин чадалтай усан цахилгаан станц барина. |
| 6. | Зүүнбаян – Улаан сумынЭмгэд багт байгуулах Хүүхдийн зусланруу цахилгаан дамжуулах агаарын шугам барина. /28 км/ |
| 7. | Бат-Өлзий сумын Үүртийн тохойн орчмоос Төвхөн хийд хүртэлх 22 км цахилгаан дамжуулах агаарын шугам барина. |
| 8 | Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн үйл ажиллагаг жигдэрүүлж, агаарын бохирдолыг бууруулна |
| 9. | "Мандалговь-Арвайхээр" чиглэлийн 220 кВт-ын 2 хэлхээт 287 км эрчим хүчний цахилгаан дамжуулах агаарын шугам татна. |
| **2.1.2.АВТО ЗАМ** | |
| 1. | Арвайхээр – Шивээ хүрэнгийн боомт чиглэлийн 336 км авто зам дагуух Гучин-Ус, Төгрөг, Богд сумдын төвүүдийг холбоно. |
| 2. | Аялал жуулчлал хөгжүүлэх Тарагт, Уянга, Хайман өвөр чиглалийн 106 км авто замыг барина. |
| 3. | Үүртийн тохойгоос Төвхөн хийд чиглэлийн 15 км авто зам, бетон гүүр барина. |
| 4. | А0301 чиглэлийн авто замаас Зүүнбаян – Улаан сум хүртэлх 40 км, Өлзийт, Баян-Өндөр сумд хүртэлх 74 км, Есөнзүйл сум хүртэлх 14.7 км, Бүрд сумын төв хүртэлх 18 км авто замуудыг тус тус барьж, "Нутгийн зам хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ. |
| 5. | Бүх сумдын төвүүдэд 3-5 км авто зам барина. |
| 6. | Улсын чанартай А0302 чиглэлийн авто замаас Баянтээг хүртэлх 22 км авто замыг барина. |
| 7. | Баянтээг – Гучин-Ус сум хүртэлх 75 км авто замыг барина. |
| 8. | Арвайхээр хотын Нисэх буудлыг нүүлгэн шилжүүлэх асуудлыг судлаж, шийдвэрлэнэ. |
| 9. | Хужирт сумын Нисэх буудлын үйл ажиллагааг сэргээн явуулна. |
| 10. | Баруунбаян-Улаан, Богд сумдад нэн шаардлагатай үед ашиглах нислэгийн аэродром байгуулна. |
| 11. | Элсэн тасархайд аялал жуулчлын зориулалтаар нислэгийн аэродром байгуулна. |
| **3.ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ–ЭРҮҮЛ ХҮНС** | |
| 1. | Махны чиглэлийн 1000-аас доошгүй үхэр бүхий эрчимжсэн аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлж, төвлөрсөн хот, суурин газрын хүн амын махны хэрэгцээг хангаж, экспортыг нэмэгдүүлнэ. |
| 2. | Эргэлтэнд оруулах боломжтой 18000га атаршсан талбайг ашиглалтад оруулж, малын тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлэн, үр үржүүлж, үрийн нөөц бүрдүүлнэ. |
| 3. | Бүрэн автоматжсан хүнсний ногооны төрөлжсөн 1000-аас доошгүй тн-ын багтаамж бүхий зоорийг Арвайхээр суманд, 500-аас доошгүй тн-ын багтаамж бүхий зоорийг Хархорин суманд байгуулж төмс, хүнсний ногоог нөөцлөх, хадгалах нөхцөлийг бүрдүүлнэ. |

| | |
|---|---|
| 4. | Байгаль, цаг уурын онцлогт тохирсон, дэвшилтэт технологийг нэвтрүүлж, дөрвөн улирлын турш шинэ ургацын хүнсний ногоо тариалах,импортын ногооны хэрэглээг бууруулах нөхцөлийг бүрдүүлж, 4.0 мянгаас доошгүй $м^2$ талбай бухий хүлэмжийн цогцолбор байгуулна. |
| **3.1 МАЛ АЖ АХУЙ ЭРҮҮЛ ХҮНС, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД** | |
| 1. | "Баянгол омог"-ийн хонин сүргийг "Баянгол үүлдэр" болгох, Гучин-Ус сумын Монголын хоолойн тэмээ, Нарийнтээл сумын Тээлийн улаан ямаа, Уянга сумын Таац, Жаргалант, Шуранга, Ар цармын сарлаг үхрийн биологийн онцлог, ашиг шимийн түвшин тогтоох судалгааны ажлыг үргэлжлүүлэх, үүлдэр, омог, хэвшлийн малыг баталгаажуулна. |
| 2. | Байгаль экологи, бэлчээрийн даацтай малын тоо, төрөл, бүтцийг уялдуулж, малыг эдийн засгийн эргэлтэд оруулж, тоо толгойгоос чанарт шилжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ. |
| 3. | "Биотехнологийн төв" байгуулж, малын чанарыг сайжруулах, мал аж ахуйн мэргэжилтнүүдийг давтан сургах, мэргэшүүлэх сургалтын бааз бий болгоно. |
| 4. | Бэлчээрийг усжуулах, сэлгэж өнжөөх, хортон мэрэгчээс хамгаалах зэргээр менежментийг сайжруулна. |
| 5. | Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, малын, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлэх замаар хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангаж, махны экспортыг нэмэгдүүлнэ. |
| 6. | Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах "Хүнсний хангамж" хөтөлбөрийг үргэлжлүүлж, гол нэр төрлийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг дэмжинэ. |
| 7. | Мал, амьтны өвчний тандалт, үзлэг, шинжилгээг сайжруулж, өвчний гаралт, тархалтыг бууруулж, бүс, нутгийн түвшинд халдварт өвчнөөр тайван байдлыг баталгаажуулна. |
| 8. | Аймгийн Мал эмнэлгийн газрын лабораторид орчин үеийн оношилгоо, шинжилгээний дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлж, оношилгооны чадавхыг сайжруулах, зах худалдааны төвд нийлүүлэгдэж байгаа мах, сүү, сүүн бүтээгдэхүүнд анхан шатны үзлэг, шинжилгээг бүрэн хийнэ. |
| 9. | Малчдыг малын эм, био бэлдмэлийг зохистой хэрэглэх арга зүйн талаарх сургалт, мэдээллээр хангах, эмийн хяналтыг сайжруулна. |
| 10. | Аймгийн Мал эмнэлгийн газрыг суурьшлын бүсээс гаргаж, шинээр барина. |
| 11. | "Шинэ хоршоо" хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд үргэлжлүүлэн өрнүүлж, хоршоодод олгож буй хамтын хариуцлагын 3-5 жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох хөтөлбөрийг хэрэгжүүлнэ . |
| 12. | Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн орсн нутгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж,үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлнэ. |
| 13 | Бүсийн үйлдвэр технологийн парк байгуулж, арьс ширэнд гүн боловсруулалт хийж торгомсог савхийг орон нутагт үйлдвэрлэх, ноос ээрэх, ноолуур угаах, самнах үйлдвэр байгуулж, Арвайхээр хотод магадлан итгэмжлэгдсэн лаборатори байгуулна. |
| 14. | Яс, тос, дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлж, бүтээгдэхүүний дотоод, гадаадын зах зээлд нийлүүлнэ. |
| 15. | Газар тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, тариаланчдыг үр, бордоо, техникийн дэмжлэгт хамруулан, дотоодын хэрэгцээний үр тарианы 90, төмс, хүнсний ногооны 70 хувийг тус тус хангана. |
| 16. | Тарагт, Арвайхээр, Хужирт, Бүрд, Баруунбаян – Улаан, Хархорин сумдын услалтын системүүдийн засвар, арчлалтыг хийж, усалгаатай талбайг нэмэгдүүлнэ. |

| | |
|---|---|
| 17. | Арвайхээр суманд эрүүл ахуй, стандартын шаардлагад нийцсэн "Малчны зах" байгуулж, мах, сүү зэрэг малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний ногоог иргэдэд нэг дороос хүргэж, малчид, тариаланчдын орлогыг нэмэгдүүлнэ. |
| 18. | Бүсийн эдийн засгийн өсөлтийн төв Хархорин, Есөнзүйл, Сант, Гучин – Ус сумдын төвүүдэд шинээр хийгдэх дэд бүтэц бүхий үйлдвэрлэлийн бүсүүдэд тулгуурлаж, малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр, цехийг байгуулж, бусад сумдаас түүхий эд бүтээгдэхүүнийг нийлүүлэх зах зээлийг бий болгоно. |
| **4. БАЙГАЛЬ ОРЧИН – НОГООН ХОТ** | |
| 1. | Төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлнэ. |
| 2. | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, мод үржүүлгийн газруудын үйл ажиллагааг өргөжүүлэх, Арвайхээр суманд хэрэгжиж буй Монгол Солонгосын "Ногоон хэрэм" төслийг үргэлжлүүлнэ. |
| 3. | Хог хаягдлыг ангилан ялгах дадал хэвшлийг бий болгож, дахин боловсруулах техник технологийг нэвтрүүлнэ. |
| 4. | Хог шатаах аргаар дулаан болон цахилгааны эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэр барьж, хог хаягдлын шинэ менежмент хэрэгжүүлнэ. |
| 5. | Ойн хомсдол доройтол, ойн хөнөөлт шавжын тархалт, хөнөөлийн голомт бүхий талбайн хэмжээг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх. |
| 6. | Байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, дэд бүтцийн хөгжилтэй уялдуулан, байгаль орчны бохирдол доройтлоос сэргийлж, агаар орчны бохирдлыг бууруулах. |
| 8. | Гол, горхи, булаг, шанд, рашааны эхийг хашиж хамгаалах ажлыг эрчимжүүлж, цас мөс, үерийн усыг хуримтлуулан, усан сан, хөв цөөрөм байгуулж ард иргэд, зэрлэг ан амьтдыг ундаалах, мод бут тарих, үйлдвэрлэл, газар тариалангийн усан хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ. |
| 9. | Сумдын хүн амыг шаардлага хангасан ундны усаар хангах, усны хайгуул судалгаа өргөжүүлэх. |
| 10. | Байгальд ээлтэй хариуцлагатай уул уурхайг дэмжиж, дэвшилтэт техник технологи нэвтрүүлж, нөхөн сэргээлтийг хийлгэх, эзэн холбогдогчгүй орхигдсон болон голын хамгаалалтын бүс дэх эвдрэлд орсон талбайг бүрэн нөхөн сэргээлгэх. |
| 11. | Тусгай сонирхлын ан агнуурыг байгалийн нөөц баялгийн зүй зохистой ашиглалтад тулгуурлан хөгжүүлж, нэн ховор, ховор амьтан, ургамлын хамгаалалтын менежментийг сайжруулна. |
| 12. | Аймгийн аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлж, шинэ Хархорум хот, Орхоны хөндийн аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх. |
| 13. | Төвхөн хийдийн хамгаалалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулан хэрэгжүүлэх, Төвхөн хийд рүү очих замыг байгалд ээлтэй дэвшилтэт арга, технологиор шийдвэрлэх. |
| 14. | Байгалийн нөөц болон Хангай нурууны экосистемд түшиглэн эрүүл мэнд, тусгай сонирхлын, өвлийн гэх мэт аяллуудыг төрөлжүүлэн хөгжүүлж, халуун рашаан бүхий газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулна. |
| 15. | Нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, аялал жуулчлалыг дагасан жижиг үйлдвэр, үйлчилгээ, бизнес эрхлэгчдийн хоршоог дэмжих. |
| 16. | Цаг уурын аэрологийн болон Радарын станцыг суурилуулж хэвийн ажиллагааг хангах. |

| | |
|---|---|
| 17. | Цаг агаарт зариудаар нөлөөлөх экспедицийн үйл ажиллагааг эрчимжүүлж газрын генераторын тоог нэмэгдүүлэн хэвийн ажиллуулах. |
| 18. | Араайхээр хотод ус, цаг уур орчны шинжилгээний лабораторийг өргөжүүлэн төвийн бүсийн “Байгаль орчны шинжилгээний Лаборатори” болгох. |
| | **5.НИИГМИЙН БОДЛОГО – ХҮНИЙ ХӨГЖИЛ** |
| | **5.1 СОЁЛ** |
| 1 | Үндэсний өв уламжлал, түүх, соёлоо түгээн дэлгэрүүлэх, соёлын боловсролтой, зөрэг хандлагатай бүтээлч иргэдийг төлөвшүүлэх “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлж, монгол бичгийн хэрэглээг нэвтрүүлж, эхлүүлнэ. |
| 2. | Төв номын сангийн байрыг засварлаж, номын баяжилтыг нэмэгдүүлэн цахим системийг нэвтрүүлнэ. |
| 3. | “Нүүдэлчин”,<br>“Торгоны зам-Хархорум”,<br>“Арвайхээрийн тал”,<br>“Занабазар арт фестивал” зэрэг олон улсын болон улс, бүсийн чанартай эвент арга хэмжээг жил бүр зохион байгуулж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ. |
| 4. | Соёл, урлагийн салбарын ажилтнуудыг чадавхжуулах гадаад, дотоодод туршлага судлуулах ажлыг хэрэгжүүлнэ. |
| 5. | Бат-Өлзий, Баянгол, Хайрхандулаан, Есөнзүйл сумдын Соёлын төвийн тоног төхөөрмжийг сайжруулж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ. |
| 6. | Богд суманд шинээр Соёлын төв барьж, Бат-Өлзий, Хайрхандулаан, Уянга, Өлзийт, Зүүнбаян-Улаан сумдын Соёлын төвд их засвар хийнэ. |
| 7. | Аймгийн төвд Соёл, гэгээрлийн ордон шинээр барьж ашиглалтад оруулна. |
| 8. | Төвхөн хийдийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллана. |
| 9. | Орхоны хөндийн соёлын дурсгалт өвийг сэргээн засварлах, хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлыг үе шаттай зохион байгуулна. |
| 10. | Шинэ музейн гадна тохижилт, үзмэр үзүүллэг дэглэлтийг хийхэд дэмжлэг үзүүлж ажиллана. |
| 11. | Эрдэнэзуу музейн үзмэрийн 50 хувийг виртуал болгоно. |
| 12. | Нүүдлийн соёл ахуйг аялал жуулчлалтай холбон эдийн засгийн эргэлтэд оруулж, малчдын орлогыг нэмэгдүүлнэ. |
| 13. | Аялал жуулчлалыг дагасан орон нутгийн онцлогт соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. |
| 14. | Түүх, соёлын өвийн хамгаалагчдын тоог нэмэгдүүлж, тэдний цалин хөлсийг нэмэгдүүлнэ. |
| 15. | Шинэ залуу уран бүтээлчдийг дэмжин ажиллаж, орон нутгийн уран бүтээлчдийн улсад болон бүсийн хэмжээнд өрсөлдүүлэх чадварыг нэмэгдүүлнэ. |
| 16. | Хужирт, Бат-Өлзий суманд спортын ордон барина. |
| | **5.2 ЭРҮҮЛ МЭНД** |
| 1. | Аймгт Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулна. |
| 2. | Хархорин Баянгол, Баруунбаян-Улаан, Өлзийт, Гучин-Ус, Төгрөг сумдыг эмчийн байртай болгоно. |
| 3. | Нарийнтээл, Богд, Бат-Өлзий, Есөнзүйл, сумдын Эрүүл мэндийн төвийг рентген |

| | |
|---|---|
| | аппаратаар хангана. |
| 4. | Хархорины сумын нэгдсэн эмнэлгийг нярайн скрининг болон бүдүүн, шулуун гэдэсний уян дурангаар хангана. |
| 5. | Бүх сум, өрхийн эрүүл мэндийн төвийг биохими, гематологийн бүрэн автомат аппаратаар хангана. |
| 6. | Бүх сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шүдний кабинет байгуулна. |
| 7. | Иргэний эрүүл мэндийн боловсрол, Эрүүл шүд арга хэмжээг хэрэгжүүлнэ. |
| 8. | Нарийнтээл, Есөнзүйл, Сант, Гучин-Ус сумдад яаралтай тусламжийн нэгж байгуулна. |
| 9. | Бүсийн оношилгоо,эмчилгээний төвийн барилгыг иж бүрэн засварлаж, бүсийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулахыг байгуулна. |
| 10. | Төвийн бүсийн хээрийн эмнэлэг байгуулна. |
| 11. | Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, гадаадад сургах бодлогыг баримтлан, шинэ технологийг нутагшуулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. |
| 12. | Эрүүл мэндийн бүх төрлийн цахим үйлчилгээг өргөжүүлнэ. |
| 13. | Уламжлалтын анагаах ухааны салбарыг өргөжүүлэн хөгжүүлж, бүсийн хэмжээнд үйлчилнэ. |
| 14. | Багийн эмч бүрийг жижиг оврын автомашинаар хангана. |
| 15. | "Элэг бүтэн Монгол", "Умайн хүзүүн хавдаргүй Монгол" хөтөлбөрүүдийг үргэлжлүүлнэ. |
| 16. | Эмийн чанар, үнэ,аюулгүй байдал, үйлдвэрлэлтэй холбоотой мэдээллийг цахимаар авах, хянах боломжийг бүрдүүлсэн health.gov.mn цахим системийн хэрэглээг өргөжүүлнэ. |
| 17. | Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, бүсийн хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаантай уялдуулан төрөлжүүлэн хөгжүүлнэ. |
| | **5.3 БИЕИЙН ТАМИР, СПОРТ** |
| 1. | Наадмын талбайг нүүлгэн шилжүүлж, "Эрийн гурван наадам" цогцолбор байгуулна. |
| 2. | Хуучин цэнгэлдэх хүрээлэнг шинэчлэн спорт-соёлын цогцолбор (UV-Arena, 8800м2) байгуулна |
| 3. | Төр хувийн хэвшлийн түншлэлээр Бат-Өлзий суманд цанын бааз байгуулна. |
| 4. | Арвайхээр сумын 9, 11, 7 дугаар багуудад тус бүр спорт заал байгуулна. (стандарт талбай 20*40) |
| 5. | Спортын ордны барилгад их засвар хийж, гадна талбай, машины зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлнэ. |
| 6. | Нийтийн спортын орчин, нөхцөлийг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлж, идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэгсдийн үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэхжүүлнэ. |
| 7. | Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, шинэ тутам хөгжиж байгаа цахим болон хотын (урбан) спортын орчин нөхцөл, төвлөрсөн байр, талбай бүхий дэд бүтцийг суурин газруудад бүтээн байгуулна. |
| | **5.4 БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААН** |
| 1. | Бага насны (0-5 нас) хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын хүртээмж, |

| | |
|---|---|
| | чанарыг сайжруулна. |
| 2. | Багшийн мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжих, нийгмийн баталгааг хангах "Багшийн хөгжил" аймгийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ. |
| 3. | Багшлах хүний нөөцийг чадавхжуулж, цэцэрлэгийн 120 багш, ерөнхий боловсролын сургуулийн 240 багш, Политехник коллежийн 40 багшийг гадаад улсад сургана. |
| 4. | Аймгийн төвд "Багш хөгжлийн ордон"-ыг байгуулж, Политехник коллеж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг бүрт байгуулагдах "Багш хөгжлийн танхим"-уудын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана. |
| 5. | Политехник коллеж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг бүрт орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн "Багш хөгжлийн танхим" байгуулна. |
| 6. | Арвайхээр, Хархорин сумдад 320 хүүхдийн суудалтай төрөлжсөн Ахлах сургууль, Баруунбаян-Улаан, Төгрөг, Баянтээг багт 120-240 хүүхдийн суудалтай сургуулийн барилга шинээр ашиглалтад оруулна. |
| 7. | Арвайхээр, Хархорин, Уянга, Есөнзүйл, Сант, Нарийнтээл сумын Баянтээг баг, Өлзийт сумдад 50-150 ортой цэцэрлэгийн барилга шинээр ашиглалтад оруулна. |
| 8. | Арвайхээр, Өлзийт, Хужирт, Бат-Өлзий сумдын сургуулиудад 100 ортой дотуур байр шинээр ашиглалтад оруулна. |
| 9. | Бүх ерөнхий боловсролын сургуулиудыг гадна биеийн тамирын талбайтай болгоно. |
| 10. | Хархорин сумын Номын хүрдэн сургууль, Баруунбаян-Улаан, Богд сумдын 1 дүгээр сургууль, Нарийнтээл сумын Баянтээг багийн сургуульд тус тус 250 хүүхдийн суудалтай спорт заалны барилга шинээр барьж, ашиглалтад оруулна. |
| 11. | Арвайхээр сумын 1, 4 дүгээр, Мэргэд, Бат-Өлзий сумын 1 дүгээр, Баруунбаян-Улаан, Баянгол, Богд сумдын 1 дүгээр, Бүрд, Зүүнбаян-Улаан, Хархорин, Хужирт сумдын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн их засварыг хийнэ. |
| 12. | Бат-Өлзий сумын 1 дүгээр, Богд сумын 1 дүгээр, Уянга сумын 1 дүгээр, Хархорин сумын 1 дүгээр, Баянгол, Гучин-Ус, Есөнзүйл, Зүүнбаян-Улаан, Хайрхандулаан Нарийнтээл, Өлзийт, Тарагт, Төгрөг, Хужирт, Уянга сумын Жаргалант багийн сургуулийн дотуур байруудад их засвар хийнэ. |
| 13. | Бат-Өлзий сумын 1 дүгээр, Уянга сумын 1 дүгээр, Хужирт сумын 2 дугаар, Тарагт, Бүрд, Уянга сумын Жаргалант багийн сургуулийн спорт заалны их засварыг хийнэ. |
| 14. | Арвайхээр сумын 2, 3, 4, 5, 6, 7, 9, 10 дугаар, Богд сумын 1 дүгээр, Хархорин сумын 1, 2, 3 дугаар, Баянгол, Баян-Өндөр, Бүрд, Есөнзүйл, Өлзийт, Тарагт, Төгрөг, Нарийнтээл сумын Баянтээг багийн цэцэрлэгүүдэд их засвар хийнэ. |
| 15. | Ерөнхий боловсролын сургууль бүрийг "Цахим кабинет"-тэй болгоно. |
| 16. | Политехник коллежийн хичээлийн болон дотуур байранд иж бүрэн их засвар хийж, сургалтын шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. |
| 17. | Сумдын сургууль, цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж, хатуу зөөлөн эдлэл, кабинетын тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлнэ. |
| 18. | Цэцэрлэг, сургууль, дотуур байрын камерийн шинэчлэлийг тогтмол хийж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ. |
| 19. | Франц, орос, хятад, япон, солонгос, англи хэлний болон спортын төрөлжсөн сургалттай анги бүлгүүдийг ерөнхий боловсролын сургуулиудад бий болгож, ажиллуулна. |

| | |
|---|---|
| 20. | Бүсийн эрэлт, хэрэгцээнд нийцэхүйц шинжлэх ухаан, технологи, хөдөө аж ахуйн чиглэлийн их, дээд сургуулийг байгуулна. |
| 21. | Яслийн бүлэг ажиллуулах боломжтой цэцэрлэг шинээр байгуулж, 1-2 хүртэлх насны хүүхдийн ясли байгуулан ажиллуулж, эцэг, эхчүүдийн хөдөлмөрлөх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ. |
| 22. | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулж, өс зүйг эрхэмлэсэн хувь хүн болгон төлөвшүүлэх олон талт арга хэмжээг тусган хэрэгжүүлнэ. |
| 23. | Тогтвортой хөгжлийн боловсролын агуулгатай нийцүүлсэн албан бус боловролын сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. |
| 24. | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын улирлын амралтыг байгаль цаг уур, үндэсний соёл, өв уламжлал, амьдралын хэв шинж, ахуйд нийцүүлнэ. |
| 25. | Ерөнхий боловсролын Мэргэд сургуулийн спорт заалыг шинэчилнэ. |
| **5.5 ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ ХАМГААЛАЛ** | |
| 1. | Гэр бүлийн тогтвортой байдлыг хангаж, гэр бүл салалтын эсрэг “ХАЛУУН АМ БҮЛ” цогц арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ. |
| 2. | “ХАЙРЛАГДСАН ХҮҮХДҮҮД” цогц төлөвлөгөөг хэрэгжүүлж, хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлнэ. |
| 3. | Хүүхдийн эрх, хөгжил, оролцоог хангаж, гэр бүлийн хөгжлийг дэмжсэн<br>- Бүсийн Хүүхдийн зуслан (Зүүнбаян-Улаан сумын нутагт)<br>-Гэр бүлийн зуслан (Арвайхээр сумын ойролцоо)<br>- Хөдөлмөр зуслан (Есөнзүйл сумын нутагт) зуслангуудыг тус тус байгуулна. |
| 4. | Хүүхэд, гэр бүлтэй ажилладаг нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, нийгмийн хамгааллын мэргэжилтнүүдийн хүний нөөцийн хөгжилд анхаарч, тэднийг чадавхжуулах ажлыг үе шаттай зохион байгуулна. |
| 5. | Хүүхдийг ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлж, бүтээн байгуулалт, зам талбай, орчныг хүүхдэд ээлтэй болгож, иргэдийн оролцоотой хүүхдийг аливаа эрсдэлээс хамгаална. |
| **5.6 ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ** | |
| 1. | Орон нутгийн нийгэм, эдийн засгийн бодлогод тулгуурлан, салбар бүрт шинээр бий болох ажлын байрыг төлөвлөн, байнгын ажлын байрыг олноор бий болгож, ажлын байрыг тогтвортой хадгалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээлд хамруулан, ажилд зуучлах. |
| 2. | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн чиг хандлагад нийцүүлж, үйлчилгээний болон бусад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд зорилтот бүлгийн болон шаардлагатай иргэдийг хамруулж, мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. |
| 3. | ХЭДС-д орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх 0,3 хувийн төсвийг залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд зарцуулна. |
| 4. | Тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөр боловсруулж, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төлөвлөгөө, арга хэмжээг хэрэгжүүлнэ. |
| 5. | Төрийн болон хувийн хувшлийн залуу, шинэ албан хаагчдад зориулж, чиглүүлэх, халамжлах хөтөлбөр хэрэгжүүлэх |
| 6. | Сумдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын ажлыг эрчимжүүлж, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах |

6217143681

| | |
|---|---|
| | **5.7 НИЙГМИЙН ХАМГААЛАЛ** |
| 1. | Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг туушталй бууруулна. |
| 2. | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ бүхий онцгой тохиолдлын амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн санхүүжилтийг бүрэн хангаж, зорилтот бүлэг рүү чиглэсэн хөтөлбөр арга хэмжээг бүрэн авч хэрэгжүүлнэ. |
| 3. | Ахмад настны өдрийн асрамжийн төв байгуулна. |
| | **5.8 НИЙГМИЙН ДААТГАЛ** |
| 1. | Нийгмийн даатгалын бүх үйлчилгээг бүрэн цахимжуулна. |
| 2. | Нийгмийн даатгалд хамрагдаж буй малчдын эзлэх хувийг нэмэгдүүлж, НДШ-ийг сар бүр төлөхгүйгээр жилдээ багтаан төлөх, хувааж төлөх зохицуулалт хийнэ. |
| 3. | Иргэдийг хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлж, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах хууль тогтоомжийг сурталчлан ажиллана. |
| | **5.9 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ЧИГЛЭСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** |
| 1. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх бүтээн байгуулалт, барилга байгууламж, худалдаа үйлчилгээний төвүүдэд 100 хувь мөрдүүлж, тэгш хүртээмжтэй үйлчилгээ, мэдээллээр хангах |
| 2. | ХБИ-ийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ. |
| 3. | ХБИ-ийн эрх, ялгамжтай байдлын талаарх зөв ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх цогц төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. |
| 4. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг түшиглэн сэргээн засах төвийг байгуулна. |
| | **5.10 ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ** |
| 1. | Эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэх |
| 2. | "Шинэ хоршоо" хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хүрээнд малчин залуучуудын жендэрийн эрх тэгш байдлыг хангах |
| 3. | Ганц бие өрх болон өрх толгойлсон эцэг, эхэд ээлтэй, хүртээмжтэй тогтолцоог хөгжүүлэхэд дэмжих |
| | **6. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ-ИРГЭН ТАНД** |
| 1. | Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог бүрдүүлж, технологийн шийдлийг сайжруулж, төрийн нууцад хамаарахаас бусад мэдээллийн санг шилэн хэлбэрээр нийтэд ил тод болгоно. |
| 2. | Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах, тасралтгүй суралцан хөгжих, хөтөлбөрийг хэрэгжүүлж, ажлын хариуцлага, бүтээмжийг нэмэгдүүлж, төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх бодлого баримтална. |
| 3. | "Нутгийн дэм" хөтөлбөрийг хэрэгжүүлж, аймагт баригдсан орон сууцны ипотекийн зээлд шинээр хамрагдаж буй төрийн албан хаагчдад дэмжлэг үзүүлнэ. |
| 5. | Үр бүтээлтэй ажилласан төрийн албан хаагчдыг гадаад, дотоодод дадлагажуулах, мэргэшүүлэх, гадаад хэлний бэлтгэл болон ахисан түвшний сургалтад хамруулна. |
| 6. | Төрийн албан хаагчийг ёс зүй, сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх бодлого гарган хэрэгжүүлнэ. |

| | |
|---|---|
| 7. | Төрийн үйлчилгээнд ашиглагдах мэдээллийн технологийн дэд бүтцийг өргөтгөж, кибер аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлнэ. |
| 8. | Багийн Засаг даргын төсвийг сумын төсөвт тусгайлан баталж, үйл ажиллагааны зардал хүрэхүйц хэмжээнд хүргэж, төрийн үйлчилгээг иргэн бүрт хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ. |
| 9. | Багийн Засаг дарга нарыг унаагаар хангана. |
| 10. | Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааг өргөтгөж, иргэдээс сумдын Засаг даргын Тамгын газарт цахимаар гомдол, мэдээллээ гаргаж, хариу хүлээн авдаг ухаалаг чатбот нэвтрүүлнэ. |
| 11. | Багийн Засаг даргын төсвийг нэмэгдүүлж тусгайлан үйл ажиллагаа нь хүрэхүйцхэмжээнд хүргэнэ. |
| 12. | Орон нутгийн төрийн байгууллагуудын үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийж, шат дамжлагыг бууруулж, төрийн бүх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэд, бизнест төвөггүй, хялбар үйлчилгээг үзүүлнэ. |
| | **6.2Хүний эрх- Шудрага ёс** |
| 1. | **"Хүний эрхийг хангах үндэсний II хөтөлбөр"**-ийг хэрэгжүүлж, хүний эрхийг хамгаалах төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, чадавхжуулна. |
| 2. | Төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанд жендэр, хүний эрхийн мэдрэмжтэй хандах, хүний эрхийн зөрчил гаргахгүй байх хяналтыг өргөжүүлнэ. |
| 3. | Эрх зүйн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, нийтээр дагаж мөрдүүлэх захиргааны хэм хэмжээний шийдвэрийг гаргахаас өмнө иргэд, иргэний нийгмийн байгууллагаар үнэлүүлж, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлнэ. |
| 4. | Авлигатай тэмцэх "5Ш" ажиллагааг хэрэгжүүлэн, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтыг нэмэгдүүлж, бүх нийтээр авлигатай тэмцэх, шударга бус зүйлийг үл тэвчих сэтгэлгээ, хандлагыг төлөвшүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ. |
| 5. | Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх,бараа бүтээгдэхүүний зохиомол хомсдол, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн хөөрөгдөлд хяналт тавих нэгж байгуулж, үйл ажиллагааг эрчимжүүлнэ. |
| 6. | Аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн конторын барилгыг барьж, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандартыг олон нийтэд нээлттэйгээр байршуулж, түүний хэрэгжилтэд олон нийтээс хяналт тавиулж хэвшүүлнэ. |
| 7. | Төрийн архив, төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулан, төрийн архив, сан хөмрөг, лавлагаа мэдээллийн цахимжуулалтыг эрчимжүүлж, үйлчилгээг хялбарчилна. |
| 8. | Өмгөөлөгчдийн зөвлөлийн хууль зүйн зөвлөгөө, сургалтын төвийн байрыг шинээр барихад дэмжлэг үзүүлж, "Хуульчдын ордон" байгуулж, хүний эрхийг хамгаалах, хууль зүйн туслалцааны чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. |
| | **Амар тайван орчин** |
| 9. | Цагдаагийн газарт эрүүлжүүлэх, саатуулах байр, Уянга, Бат-Өлзий сумдад Цагдаагийн тасгийн барилга, Цагдаагийн газарт спорт заал шинээр барьж ашиглалтад оруулна. |
| 10. | Шүүхийн шинжилгээний бүсийн төвийн стандартад нийцсэн шинэ барилгыг барьж, олон улсын стандартад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангана. |

| | |
|---|---|
| 11. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албан контор, Цагдан хорих байрыг шинэ байранд шилжүүлэн барьж ашиглалтад оруулна. |
| 12. | Дотоод цэргийн хамгаалалтад Эрдэнэзуу мүзей, "Бат – Эрдэнэзуу", Шанх, Төвхөн хийдүүд, дулааны цахилгаан станц, Хархорин, Хужирт сумдын усан хангамжийн системүүдийг дотоод цэргийн хамгаалалтад авч, тус байгууллагын албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, шаардлагатай унаа, багаж, техник хэрэгслээр хангахад нь дэмжлэг үзүүлнэ. |
| 13. | Гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн талбай, улсын болон орон нутгийн чанартай авто замын хяналтыг сайжруулж, теле-камерын тоог нэмэгдүүлэх, хүчин чадлыг сайжруулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ. |
| 14. | Архидан согтуурахтай тэмцэх сайн дурын АА бүлгэмүүдийн үйл ажиллагааг өргөжүүлж, сэтгэц наркалогийн төвтэй хамтран ажиллаж, архины хамаарлыг эмчлэх цогц хөтөлбөр хэрэгжүүлнэ. |
| 15. | Гэмт хэрэг, зөрчлийн нутаг дэвсгэрийн, шалтгаан нөхцөлийн судалгааг шинэчилж, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ. |
| 16. | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхэд, эмэгтэйчүүдийг түр хамгаалах байрын үйл ажиллагааг менежментийн гэрээгээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг эхлүүлнэ. |
| **Батлан хамгаалах-гамшгийн үеийн бэлэн байдал** | |
| 17. | Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд залуучуудад цэрэг эх оронч, үзэл төлөвшүүлнэ. |
| 18. | Бат-Өлзий, Уянга, Нарийнтээл сумдад эрэн хайх, аврах бүлэг байгуулж, сумдыг гамшгаас хамгаалах иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангана. |
| 19. | Аймгийн Онцгой байдлын газрын барилгыг шинээр барьж, Гучин-Ус суманд улсын нөөцийн салбарыг байгуулна. |
| 20. | Орон нутгийн гамшгаас хамгаалах болон дайчилгааны бэлэн байдлыг хангах зориулалттай дадлага сургуулиулалтын төвийг байгуулна. |
| 21. | Аюулын төрөл бүрээр гамшиг, ослын эрсдэлийн үнэлгээг хийж, онцгой байдлын албаны санхүүжилт, хангамж, хариуцлага, бэлэн байдлын стандартыг хэрэгжүүлж, албан хаагчдын тоног төхөөрөмж, хувцас хэрэглэлийг үе шаттай шинэчилнэ. |

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.17 № 317

танай ______ -ны № ______ -т

БАЯНГОЛ СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5 дахь хэсгийг үндэслэн Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох Баянгол сумын Монгол ардын намын хорооны Сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүргүүлж байна.

Хавсралт 14 хуудастай.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР О.БАТЖАРГАЛ

6225020510

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangal@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.17 № 195
танай ____________-ны №____________-т

БАЯНГОЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 5.4-т заасны дагуу Төрийн аудитын байгууллага Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох Баянгол сумын Монгол ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох Баянгол сумын Монгол ардын намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох Баянгол сумын Монгол ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны

төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Баянгол сумын Монгол ардын намын хорооны Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баянгол сумын Монгол ардын намын хорооны мөрийн хөтөлбөр (.8..хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Баянгол сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

